

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Чингис хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитор: Н.Хэрлэнбаяр Утас: 89051308 Цахим хаяг: kherlenbayarn@audit.gov.mn Цахим хаяг: www.audit.mn
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 531

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Сумын ИТХ-аар орон нутгийн төсвийг 271,988.6 мянган төгрөгөөр алдагдалтай баталж, төсөв батлагдаагүй 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдэл 65,189.3 мянган төгрөгийг бүрэн төлөвлөөгүй.
- ✓ Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 225,067.8 мянган төгрөгийн 1 төсөл, арга хэмжээний худалдан авалтыг зохион байгуулсан.
- ✓ ОНХС-ийн дансанд малын тоо толгойн албан татварын 375.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.
- ✓ ХХС-ийн 223,404.6 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэл нь чанаргүй зээлийн ангилалд шилжсэн, зээлийг эргэн төлүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй.

- ✓ ИТХ нь бараа материалын 2,330.8 мянган төгрөгийн үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй.
- ✓ Аймгийн ИТХ-аас зохион байгуулсан "Хурал-цом" тэмцээнд оролцож 1,267.0 мянган төгрөгийг зочид буудлын төлбөрт, 2,617.0 мянган төгрөгийг хоолны зардалд зарцуулсан.
- ✓ Орон нутгийн нөөц хөрөнгөнөөс 3,500.0 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 800.0 мянган төгрөгийг малчдын зөвлөгөөний зардалд, урсгал засварын зардлаас 1,721.6 мянган төгрөгийг цагдаагийн байрны засварт тус тус зориулалт бусаар зарцуулсан.
- ✓ Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ 49,866.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтын тайланг гаргаагүй.

Энэ нь дараах хууль тогтоомжийг зөрчсөн байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх,"; 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх,"; 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:"; 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах,"; 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;"
- ✓ Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах,";
- ✓ Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх,"; 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна."
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна."13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.",
- ✓ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралт "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5-д "зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх" 7.3-т "Сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг сумын Засаг дарга хариуцан арилгах бөгөөд хөнгөлөлттэй зээлийг зориулалтын

бусаар зарцуулсан, зээлийн гэрээнд заасан заалтыг зөрчсөн зээлдэгчийн зээлийн гэрээг цуцалж, зээлийг Сангийн дансанд буцаан төвлөрүүлэх ажиллагааг зохион байгуулна”

- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т “батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах”
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д “байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно”
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2-т “Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн дор дурдсан хугацаанд явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнана.”, 70.2.2-т “түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс”/, 73.2-т “Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана.” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 5,150,130.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,661,016.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 1,489,114.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,097,310.7 мянган төгрөг буюу 79.6 хувьтай байна.

Аудитын гол асуудал

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,148,993.5 мянган төгрөгийн 27 алдаа, зөрчил илэрч 131,020.5 мянган төгрөгийн 12 алдааг санхүүгийн тайланд залруулж, 14,680.3 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 779,888.1 мянган төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 223,404.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн болно.

Орон нутгийн төсөвт 1,071,200.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,687,944.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 616,744.2 мянган төгрөгөөр буюу 57.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Сумын ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Наймдугаар хуралдаанаар сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны биелэлтийг 90.3 хувь буюу “үр дүн гарсан” гэж дүгнэсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сангаас 1,510,514.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс 713,825.1 мянган төгрөгийн 13 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, шинэ суурьшлын бүсэд айраг хорооллын 04-ийн шугам татах, эгнээ гудамжны хотгор хонхор засварлах, зураг төсөв хийх, Хэнтий багийн дахин төлөвлөлт, Хурх багт гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, сумын цэвэр усны насос, станцын барилга, тоног төхөөрөмжийн ажлын зураг төсөв хийлгэх зэрэг ажлууд тус тус хийгдээгүй байна.

Сумын төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөх, батлагдсан төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red official stamp of the State Audit Agency of Mongolia is visible, containing the text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТ АГЫН ТӨСӨӨ' (State Audit Agency of Mongolia). A handwritten signature in black ink is written over the stamp.

Ж.ГАНБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан**

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		2,513,356.52	2,199,363.22
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	1,388,863.9	1,650,133.31
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	852,123.91	319,666.46
4	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	260,618.72	221,563.45
5	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	11,750	8,000
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		9,012,945.51	9,387,762.07
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	9,012,945.51	9,387,762.07
8	1.2.2.02 Биет хөрөнгө		8,567,658.71	8,942,725.27
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	445,286.8	445,036.8
10	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		11,526,302.03	11,587,125.3
11	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		95,449.81	441,148.27
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		95,449.81	441,148.27
13	2.1.1.03 Өглөг		11,031.75	84,051.57
14	2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	84,418.06	357,096.7
15	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		11,430,852.22	11,145,977.02
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		11,430,852.22	11,145,977.02
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		961,600.37	961,600.37
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		10,265,958.27	9,981,083.07
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		203,293.58	203,293.58
20	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		11,526,302.03	11,587,125.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		6,139,083.44	5,363,212.7
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		1,414,835.51	1,467,806.49
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		807,888.53	768,448.44
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		807,888.53	768,448.44
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		60,067.88	77,840.08
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		546,879.09	621,517.97
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	467,508.87	3,895,406.22
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	2,090,878.28
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,256,739.06	0.0
10	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	4,647,983.77	4,864,315.34
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		4,647,983.77	4,838,415.34
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,593,471.11	4,712,094.83
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		985,981.1	1,309,812.16
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		123,655.63	158,028.98
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,065,608.46	1,114,165.87
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		158,803.64	146,325.97
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		14,955.1	22,702.14
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		90,998.04	65,203.8
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		30,206	23,100
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		328,472.68	536,639.22
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		1,794,790.47	1,336,116.68
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		54,512.66	126,320.51
23	1.1.2.02 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0.0	25,900
24	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		1,491,099.68	498,897.36
25	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		347,132.64	783,772.56
26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-347,132.64	-783,772.56
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)		1,143,967.03	-284,875.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,286,837.41		10,286,837.41
2	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,286,837.41		10,286,837.41
3	1.1.1.1.5 Өмчид гарсан өөрчлөлт	47.78		47.78
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,143,967.03		1,143,967.03
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	11,430,852.22		11,430,852.22
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	11,430,852.22		11,430,852.22
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,430,852.22		11,430,852.22
8	1.7 Тайлант үеийн үр дүн	-284,875.2		-284,875.2
9	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	11,145,977.02		11,145,977.02

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	5,960,808.48	5,362,382.95
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,414,835.51	1,467,806.49
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	807,888.53	768,448.44
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	60,067.88	77,840.08
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	546,879.09	621,517.97
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	22,645.69	84,434.69
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	40,979.07	55,012.33
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	483,254.34	482,070.95
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	293,745.41	3,894,576.46
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	293,745.41	585,380.91
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	2,550,500.36
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	758,695.2
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,252,227.56	0.0
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,487,801.06	4,342,769.08
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	4,487,801.06	4,342,769.08
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,975,706.33	4,221,602.56
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	989,972.28	1,295,820.83
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	125,642.87	156,293.48
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,065,270.76	1,112,943.32
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	156,271.63	173,024.95
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	15,631.7	2,718.5
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	49,778.54	67,498.97
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	30,206	23,100
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	316,453.54	558,983.88
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	1,226,479.01	831,218.62
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	512,094.73	121,166.51
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,473,007.42	1,019,613.87
28	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	475,068.75	757,725.06
29	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	475,068.75	757,725.06

30	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	475,068.75	757,725.06
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-475,068.75	-757,725.06
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	0.0	619.4
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	0.0	-619.4
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	997,938.67	261,269.41
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	390,925.23	1,388,863.9
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,388,863.9	1,650,133.31

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Төлөвлөгөө	2. Гүйцэтгэл	Зөрүү
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,160,729.80	6,846,559.20	314,170.60
11	3.1.01.1.1 Татварын орлого	988,050.00	1,467,806.49	(479,756.49)
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	798,000.00	768,448.44	29,551.56
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	798,000.00	768,448.44	29,551.56
110001	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	560,000.00	548,919.33	11,080.67
110002	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	180,000.00	143,560.48	36,439.52
110003	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	53,000.00	65,871.86	(12,871.86)
110004	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	5,000.00	10,096.77	(5,096.77)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	14,000.00	77,840.08	(63,840.08)
113001	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	10,000.00	53,529.18	(43,529.18)
113002	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	4,000.00	3,225.00	775.00
113004	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	-	21,085.90	(21,085.90)
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	176,050.00	621,517.97	(445,467.97)
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	28,000.00	84,434.69	(56,434.69)
118001	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	15,000.00	72,595.85	(57,595.85)
118006	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	3,000.00	2.60	2,997.40
118009	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	10,000.00	11,836.24	(1,836.24)
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	75,000.00	55,012.33	19,987.68
118101	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	75,000.00	55,012.33	19,987.68
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,050.00	482,070.95	(409,020.95)
118201	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	59,400.00	467,908.37	(408,508.37)
118202	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	13,650.00	14,162.58	(512.58)
12	3.1.01.1.2 Татварын бус орлого	6,172,679.80	5,378,752.72	793,927.08
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	95,744.20	260,094.21	(164,350.01)
120003	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	13,000.00	26,185.00	(13,185.00)
120004	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	12,592.20	47,155.99	(34,563.79)
120010	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	45,152.00	53,040.00	(7,888.00)
120009	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	25,000.00	133,713.22	(108,713.22)
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	5,318,240.40	4,359,963.31	958,277.09
122003	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,767,526.40	1,767,526.50	(0.10)

122005	3.1.01.1.2.3.5	Төсвөөс санхүүжих	3,550,714.00	2,592,436.81	958,277.19
123	3.1.01.1.2.4	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	758,695.20	758,695.20	-
123002	3.1.01.1.2.4.2	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	758,695.20	758,695.20	-
II	3.1.01.2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,150,130.00	7,446,887.08	(2,296,757.08)
21	3.1.01.2.1	УРСГАЛ ЗАРДАЛ	3,547,866.00	6,688,542.62	(3,140,676.62)
210	3.1.01.2.1.1	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,471,672.50	3,266,186.21	205,486.29
2101	3.1.01.2.1.1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,277,859.00	1,278,768.10	(909.10)
210101	3.1.01.2.1.1.1.01	Үндсэн цалин	583,717.40	570,620.45	13,096.95
210102	3.1.01.2.1.1.1.02	Нэмэгдэл	427,508.90	496,229.66	(68,720.76)
210103	3.1.01.2.1.1.1.03	Унаа хоолны хөнгөлөлт	79,672.00	66,718.82	12,953.18
210104	3.1.01.2.1.1.1.04	Урамшуулал	48,104.00	43,090.47	5,013.53
210105	3.1.01.2.1.1.1.05	Гэрээт ажлын хөлс	138,856.70	102,108.70	36,748.00
2102	3.1.01.2.1.1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,516.60	156,293.48	3,223.12
210201	3.1.01.2.1.1.2.01	Тэтгэврийн даатгал	108,471.30	106,781.52	1,689.78
210202	3.1.01.2.1.1.2.02	Тэтгэмжийн даатгал	12,761.20	12,679.82	81.38
210203	3.1.01.2.1.1.2.03	ҮОМШӨ-ний даатгал	6,380.70	6,339.96	40.74
210204	3.1.01.2.1.1.2.04	Ажилгүйдлийн даатгал	6,380.70	6,078.46	302.24
210205	3.1.01.2.1.1.2.05	Эрүүл мэндийн даатгал	25,522.70	24,413.73	1,108.97
2103	3.1.01.2.1.1.3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,214,188.10	1,112,943.32	101,244.78
210301	3.1.01.2.1.1.3.01	Гэрэл, цахилгаан	158,966.80	137,183.91	21,782.89
210302	3.1.01.2.1.1.3.02	Түлш, халаалт	998,292.40	947,137.22	51,155.18
210303	3.1.01.2.1.1.3.03	Цэвэр, бохир ус	56,928.90	28,622.20	28,306.70
2104	3.1.01.2.1.1.4	Хангамж, бараа материалын зардал	69,941.10	60,863.20	9,077.90
210401	3.1.01.2.1.1.4.01	Бичиг хэрэг	6,274.30	5,874.25	400.05
210402	3.1.01.2.1.1.4.02	Тээвэр, шатахуун	53,000.00	46,530.35	6,469.65
210403	3.1.01.2.1.1.4.03	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,368.20	3,350.70	2,017.51
210405	3.1.01.2.1.1.4.05	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,113.70	1,297.60	(183.90)
210406	3.1.01.2.1.1.4.06	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,184.90	3,810.30	374.60
2105	3.1.01.2.1.1.5	Нормативт зардал	4,347.60	2,718.50	1,629.10
210503	3.1.01.2.1.1.5.03	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,347.60	2,718.50	1,629.10
2106	3.1.01.2.1.1.6	Эд хогшил, урсгал засварын зардал	61,245.30	56,227.80	5,017.50
210601	3.1.01.2.1.1.6.01	Багаж, техник, хэрэгсэл	5,581.20	3,975.70	1,605.50
210603	3.1.01.2.1.1.6.03	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943.10	-	943.10

210604	3.1.01.2.1.1.6.04	Урсгал засвар	54,721.00	52,252.10	2,468.90
2107	3.1.01.2.1.1.7	Томилолт, зочны зардал	29,000.00	23,100.00	5,900.00
210702	3.1.01.2.1.1.7.02	Дотоод албан томилолт	29,000.00	23,100.00	5,900.00
2108	3.1.01.2.1.1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,783.90	445,422.89	58,361.01
210801	3.1.01.2.1.1.8.01	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	494,028.20	438,944.13	55,084.07
210802	3.1.01.2.1.1.8.02	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,481.70	520.00	961.70
210803	3.1.01.2.1.1.8.03	Даатгалын үйлчилгээ	1,118.30	1,014.00	104.30
210804	3.1.01.2.1.1.8.04	Тээврийн хэрэгслийн татвар	818.20	335.74	482.46
210805	3.1.01.2.1.1.8.05	Тээврийн хэрэгслийн оношлогоо	378.60	-	378.60
210806	3.1.01.2.1.1.8.06	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,595.40	1,434.00	1,161.40
210807	3.1.01.2.1.1.8.07	Газрын төлбөр	3,363.50	3,175.02	188.48
2109	3.1.01.2.1.1.9	Бараа үйлчилгээний бусад зардал	151,790.90	129,848.92	21,941.98
210901	3.1.01.2.1.1.9.01	Бараа үйлчилгээний бусад зардал	124,548.90	109,627.92	14,920.98
210902	3.1.01.2.1.1.9.02	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	27,242.00	20,221.00	7,021.00
213	3.1.01.2.1.4	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,193.50	3,422,356.41	(3,346,162.91)
2131	3.1.01.2.1.4.1	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	3,349,576.41	(3,349,576.41)
213103	3.1.01.2.1.4.1.03	Төсвийн санхүүжилт	-	3,349,576.41	(3,349,576.41)
2132	3.1.01.2.1.4.2	Бусад урсгал шилжүүлэг	76,193.50	72,780.00	3,413.50
213205	3.1.01.2.1.4.2.04	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,612.00	69,480.00	132.00
213209	3.1.01.2.1.4.2.08	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,581.50	3,300.00	3,281.50
22	3.1.01.2.2	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,537,114.00	757,725.06	779,388.94
223001	3.1.01.2.2.4	Бусад хөрөнгө	1,537,114.00	757,725.06	779,388.94
23	3.1.01.2.3	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	65,150.00	619.40	64,530.60
230001	3.1.01.2.3.1	Эргэж төлөгдөх зээл	65,150.00	619.40	64,530.60
8	3.1.01	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	2,010,599.80	(600,327.88)	2,610,927.68
9	3.1	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(2,010,599.80)	600,327.88	(2,610,927.68)
7	3	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(2,010,599.80)	600,327.88	(2,610,927.68)
4	4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,341,159.00	(1,341,159.00)
5	5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,497,970.72	(1,497,970.72)

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	782,973.86
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	782,973.86
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	782,973.86
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	782,973.86
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	782,973.86
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,843.67
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	758,130.19
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	734,887.35
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	734,887.35
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	734,887.35
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	26,264.98
210401	1.1.1.2.1.1.4.1 Бичиг хэрэг	3,552.00
210402	1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун	16,282.80
210403	1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	100.00
210405	1.1.1.2.1.1.4.5 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,330.18
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	11,271.17
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	11,271.17
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	697,351.20
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	697,351.20
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	48,086.51
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(48,086.51)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(48,086.51)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 6 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, 2 ОНӨААТҮГ нийт 11 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллагын санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан байна.

Аймаг дахь Төрийн аудитын газар Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд, “Платиниум прогресс аудит” ХХК Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн.

3.1 Тус сумын харьяа орон нутгийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 122,073.0 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илрүүлснээс 59,534.9 мянган төгрөгийн 8 алдааг санхүүгийн тайланд залруулж, 62,538.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал

1. Тайлант оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор 2,330.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолж, баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Аймгийн ИТХ-аас зохион байгуулсан "Хурал-цом" тэмцээнд зориулан 1,267.0 мянган төгрөгийг буудал, 2,617.0 мянган төгрөгийг хоолны зардалд зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Засаг даргын тамгын газар

1. Санхүүгийн тайланд ХХОАТ-ын өглөгийг 1,430.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.
2. Барилга байгууламж дансны хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл дэлгэрэнгүй тайлангаас 4,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн, авто тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж дансны тайлант оны элэгдлийн зардлыг 2,586.4 мянган төгрөгөөр дутуу тооцож тайлагнасныг залруулсан.
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант оны үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 5,662.7 мянган төгрөгөөр илүү тайлагнасныг залруулсан.
4. ОНХС-аас хөрөнгөөр бэлтгэсэн 28,800.0 мянган төгрөгийн ажлыг бүртгэж аваагүй байсныг санхүүгийн тайланд орлогоор бүртгэж залруулсан.
5. Орон нутгийн нөөц хөрөнгөнөөс 3,500.0 мянган төгрөгийг, хичээл үйлдвэрлэлийн зардлаас 800.0 мянган төгрөгийг малчдын зөвлөгөөний зардалд, урсгал засварын зардлаас 1,721.6 мянган төгрөгийг цагдаагийн байрны засварт тус тус зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Орон нутгийн хөгжлийн сан

1. Мал угаах ванн, худаг засварын ажилд өмнөх онд олгосон 5,500.0 мянган төгрөгийг авлагаар тусгасныг урьдчилж гарсан зардалд бүртгэж залруулсан.

Хоршоо хөгжүүлэх сан

1. Зээлийн хүүгийн авлагын 2,150.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд зээлийн авлагаар бүртгээснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулсан.
2. ШШГГ-т шилжүүлсэн 7 иргэний шийдвэр гүйцэтгэлийн төлбөрийг санхүүгийн тайланд эргэж төлөгдөх зээл дансанд тусгасныг бараа үйлчилгээний бусад зардалын дансанд бүртгэж залруулсан.

Өмнөдэлгэр нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ

1. Тайлант онд 49,866.0 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримтад үндэслэн тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Хэнтий шинэс сүм дундын ойн анги ОНӨААТҮГ

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 8,935.6 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, төвлөрүүлэх шилжүүлгийн тохируулах бичилт хийгээгүй байсныг залруулав.

3.2 Тус сумын харьяа улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 206,957.1 мянган төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс 58,948.2 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 14,304.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 133,704.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

Соёлын төв

Аудитаар, алдаа, зөрчил илрээгүй болно.

Эрүүл мэндийн төв

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 18,446.3 мянган төгрөгийн тохируулга хийгээгүй байсныг зарцуулсан.
2. Сургалтын төсвийн ихэнх хувь болох 7,322.6 мянган төгрөгийг зөвхөн цайны зардалд төсөвлөн зарцуулж сургалтын үйл ажиллагаа зохион байгуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Ерөнхий боловсролын сургууль

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланд 40,501.9 мянган төгрөгийн тохируулга хийгээгүй байсныг зарцуулсан.
2. Тайлант онд 7 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 6,550.0 мянган төгрөгийн цалин давхардуулж, нэг багшид гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн

урамшууллыг жилд олгох хувь хэмжээнээс 2,522.8 мянган төгрөгөөр илүү олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3. Мэдээллийн технологийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчин 1,490.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

4. Шилэн дансны нэгдсэн системд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 124,891.7 мянган төгрөгийн 5 шийдвэрийн хуулбарын байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

Хүүхдийн цэцэрлэг

1. Тайлант онд 5 ажилтанд ээлжийн амралтыг биеэр эдлүүлээгүй 5,231.8 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

3.3 Сумын засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар:

Өмнөдэлгэр сумын Засаг даргын нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар 12,537.3 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд замд яваа мөнгө 8,503.4 мянган төгрөгийг тусгаагүй байсныг залруулсан.
2. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд байгууллагад өгөх өглөгийг 4,033.9 мянган төгрөгөөр илүү тусгасныг залруулсан.

Аудитаар нийт 807,425.9 мянган төгрөгийн 6 зөрчил илэрч, 375.7 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 583,645.7 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 223,404.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

3.3.1 Төлбөрийн акт

1. ОНХС-ийн дансанд малын тоо толгойн албан татварын 375.7 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

3.3.2 Албан шаардлага

1. Сумын ИТХ-аар орон нутгийн төсвийг 271,988.6 мянган төгрөгөөр алдаагдалтай баталсан байна.
2. Тайланд оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх 225,067.8 мянган төгрөгийн ажлын худалдан авалтыг зохион байгуулсан байна.
3. Сумын ИТХ-аар төсөв нь батлагдаагүй 21,400.0 мянган төгрөгийн 3 арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.
4. ОНХС-ийн урьд оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг 65,189.3 мянган төгрөгөөр дутуу төлөвлөсөн байна.

3.3.3 Зөвлөмж

1. ХХС-ийн 14 зээлдэгчийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдэл 223,404.6 мянган төгрөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийн авлагын үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		НББ-ийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Буруу тусган илэрхийлсэн		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Үүнээс				Зөвлөмж	
									Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	4.0	42,479.5		-	4.0	42,479.5			4.0	42,479.5				
ОНХС	1.0	5,500.0	1.0	5,500.0		-			1.0	5,500.0				
ХХС	2.0	2,619.9		-	2.0	2,619.9			2.0	2,619.9				
БХС		-		-		-								
ОНӨААТҮГ	1.0	8,935.6		-	1.0	8,935.6			1.0	8,935.6				
ОНБ-ын дүн	8.0	59,534.9	1.0	5,500.0	7.0	54,034.9	-	-	8.0	59,534.9	-	-	-	-
ЕБС	1.0	40,501.9			1.0	40,501.9			1.0	40,501.9				
Цэцэрлэг		-												
Соёлын төв		-												
ЭМТ	1.0	18,446.3							1.0	18,446.3				
УТБ-ын дүн	2.0	58,948.2	-	-	1.0	40,501.9	-	-	2.0	58,948.2	-	-	-	-
Өмнөдэлгэр Засаг дарга	2.0	12,537.3			1.0	4,033.9	1.0	8,503.4	1.0	12,537.3				
ТТЗ-ын дүн	2.0	12,537.3	-	-	1.0	4,033.9	1.0	8,503.4	1.0	12,537.3	-	-	-	-
Нийт дүн	12.0	131,020.5	1.0	5,500.0	9.0	98,570.8	1.0	8,503.4	11.0	131,020.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗДТГ	1.0	6,021.6			1.0	6,021.6							
ИТХ	2.0	2,330.8			2.0	2,330.8							
ОНХС	-	-				-							
ХХС	-	-				-							
ОНӨААТҮГ	1.0	49,866.0			1.0	49,866.0							
ОНБ-ын дүн	4.0	58,218.4	-	-	4.0	58,218.4	-	-	-	-	-	-	-
ЕБС	2.0	10,562.8	1.0	9,072.8	1.0	1,490.0							
Цэцэрлэг	1.0	5,231.8	1.0	5,231.8									
Соёлын төв	-	-				-							
ЭМТ	1.0	7,322.6			1.0	7,322.6							
УТБ-ын дүн	4.0	23,117.2	2.0	14,304.6	2.0	8,812.6	-	-	-	-	-	-	-
Өмнөдэлгэр Засаг дарга	6.0	582,358.1	1.0	375.7	4.0	358,577.9	1.0	223,404.6					
ТТЗ-ын дүн	6.0	582,358.1	1.0	375.7	4.0	358,577.9	1.0	223,404.6	-	-	-	-	-
Нийт дүн	14.0	663,693.8	3.0	14,680.3	10.0	425,608.9	1.0	223,404.6	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
ЗДТГ	-	-											
ИТХ	1.0	4,319.7			1.0	4,319.7							
ОНБ-ын дүн	1.0	4,319.7	-	-	1.0	4,319.7	-	-	-	-	-	-	-
ЕБС	1.0	124,891.7			1.0	124,891.7							
УТБ-ын дүн	1.0	124,891.7	-	-	1.0	124,891.7	-	-	-	-	-	-	-
Өмнөдэлгэр Засаг дарга	1.0	225,067.8			1.0	225,067.8							
ТТЗ-ын дүн	1.0	225,067.8	-	-	1.0	225,067.8	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	3.0	354,279.2	-	-	3.0	354,279.2	-	-	-	-	-	-	-

5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	6	4	2		4			
2	ОНТС	2		2					
3	ОНӨҮГ	2		2					
4	ТТЗ	1	1				1		
	НИЙТ	11	5	6		4	1		



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 90-А2371281
ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлогын 375,700.00 (гурван зуун далан таван мянга долоон зуу) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;", 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй." гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Малын тоо толгойн албан татварын 375,700.00 (гурван зуун далан таван мянга долоон зуу) төгрөгийг Төрийн сан банк дахь ерөнхий орлогын 100180800910 тоот данснаас "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 100180852400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Засаг дарга /Р.Энхтөр/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н. Наран

Н.ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 286-А/2371281

Чингис хот

ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн төсвийг 271,988,558.9 (хоёр зуун далан нэгэн сая есөн зуун наян найман мянга таван зуун тавин найман төгрөг есөн мөнгө) төгрөгөөр алдагдалтай төлөвлөж, батлуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг алдагдалтай төлөвлөдөг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Р.Энхтөр-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н. Хэрлэнбаяр



Ж. ГАНБААТАР

Ж. ГАНБААТАР

Н. ХЭРЛЭНБАЯР



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 287-А237/281

Чингис хот

ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн үлдэгдэл 65,189,316.00 (жаран таван сая нэг зуун наян есөн мянга гурван зуун арван зургаа) төгрөгийг бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх," 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх," 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ," 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах," гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Р.Энхтөр-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Н.Хэрлэнбаяр

Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБАЯР



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25

Дугаар 285-А237/281

Чингис хот

ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар төсөв батлагдаагүй 21,400,000.00 (хорин нэгэн сая дөрвөн зуу) төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 14 дүгээр зүйлийн 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах," 60 дугаар зүйлийн 60.3-т "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно", 60.3.6-д "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор төсөв нь батлагдаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Р.Энхтөр-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР

Н.ХЭРЛЭНБАЯР



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25

Дугаар 284-А2371281

Чингис хот

ХЭА-2026/002/НА-СТА-ТТЗ

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс хойш 225,067,820.00 (хоёр зуун хорин таван сая жаран долоон мянга найман зуун хорь) төгрөгийн 1 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-т "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Р.Энхтөр-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Н.ХЭРЛЭНБЯАР